Preserving Mongolian Culture: BUDDHISM Chapter 2 Highlights and Heroes of Mongolian Buddhism

Mongolia is a proud country that was bound together as a nation by Chinggis Khan, and unified in spirit by the precious teachings of Buddhism. In this chapter, we look at Mongolia's rich and unique Buddhist history.

For over two thousand years, Mongolia was a leader in Buddhist culture, excelling in philosophy, art and science. During the 70 years of Communist suppression, this unique culture barely survived. Forced to practice in secret, monks and lay people struggled to keep the precious teachings alive. Two generations of Mongolians were robbed of their Buddhist cultural identity.

Today, the younger generation has a powerful opportunity to learn how the treasures of their past can make them leaders in a world turning to Buddhism. Чингис хааны тааллаар их гүрэн болон хүчирхэгжиж, Бурханы шашны хосгүй сургааль дор оюун санаагаараа нэгдсэн омог бардам ард түмнийг Монгол гэдэг билээ. Энэ удаагийн цуврал нэвтрүүлгээрээ бид тэрхүү Монголчуудын хосгүй баялаг түүхээс цухасхан үзүүлье.

2000 гаруй жилийн турш Монголчууд Бурханы шашны гүн ухаан, урлаг, мэргэдээрээ гайхагдаж байсан төдийгүй энэ талаараа дэлхийд тэргүүлж байлаа. Харин сүүлийн далан жил үргэжилсэн коммунист дэглэмийн дараа энэхүү хосгүй өв соёлоос бараг юу ч үлдсэнгүй. Шашнаа нууцаар л шүтэхээс аргагүй болсон хувраг хийгээд хар хүмүүс хойч үедээ Бурханы шашны үнэт сургааль, соёлоо өвлүүлэхийн тулд шургуу тэмцэх хэрэгтэй болсон юм. Ийнхүү өөрсдийн уламжлалт шашин соёлоосоо ангид монголын бүхэл бүтэн хоёр ч үе буй болсон билээ.

Байдал хэдий бэрхшээлтэй, хүнд байгаа ч, Бурханы шашин дэлхий ертөнцөд хүчтэйгээр түгэн дэлгэрч буй энэ үед, өвөг дээдсийнхээ үлдээсэн оюуны үнэт өв, шавхагдашгүй эрдэнэсийг ашиглан, дэлхийд тэргүүлэх боломж Монголын залуу үед байсаар байгаа юм.

His Holiness the 14th Dalai Lama

When it comes to other countries, each nation has it's own religious heritage. So when the people of these various countries follow the religious traditions in which they were raised, their native religious heritage, then this is very stable. This is firm. But in the case of Mongolia and Tibet, our own native religious heritage is Buddhist. We are followers of the Buddha. It is our religious tradition in which we have been raised by our own parents. So, it is important that we preserve our own native religious heritage.

Richard Gere

Now, in Mongolia, you have this incredible rich history of Buddhism, which has served you well for thousands of years. And you had this incredibly brutal period, a tragedy of 70 years of domination by a Communist overculture. You are in a very difficult position right now.

Дээрхийн Гэгээнтэн Далай лам

Улс үндэстэн болгонд өөрийн гэсэн шашин шүтлэг, нандин өв уламжлал байдаг. Тэрхүү өсч торниж, хүмүүжсэн уламжлалт шашиндаа хир зэрэг үнэнч байгаагаас нь тухайн үндэстэн цаашдаа бат бэх, тогтвортой оршин тогтнох эсэх нь хамаардаг. Харин Монгол, Төвдийн хувьд, бидний үндэсний, язгуурын уламжлалт шашин бол «Бурханы шашин» юм. Өөрөөр хэлбэл, бид бүгдээрээ Бурхан багшийг шүтэн дагагчид билээ. Энэ бол бидний өв уламжлал. Энэ л шашны хүмүүжлээр эцэг эх маань биднийг өсгөссөн. Тиймээс бид үндэснийхээ шашныг хадгалан хамгаалах нь тун чухал болоод байна.

Ричард Гир

Монголчууд та бүгд үнэхээр гайхмаар оюуны баялаг хийгээд мянга мянган жилийн турш баяжин өвлөгдөж ирсэн Бурханы шашны түүхтэй билээ. Гэлээ ч тэрхүү нандин өв соёлыг сүүлийн далаад жилийн турш ноёрхсон коммунист дэглэм хайр найргүй устгасан эмгэнэлтэй гашуун түүхийг амсжээ. Одоо байдал үнэхээр хүнд байгаа гэдгийг би сайн ойлгож байна.

Ven. Purevbat

The younger generation doesn't know about our own identity and our own culture. And during this time, Mongolian culture is being exploited. I think I have to educate them. I have to hurry to make them know about our culture and also, I have to act as a transition between the old generation and the new generation, without mistake.

Buddhism

Buddhism, one of the fastest growing religions in the West, started in India. Over 2,500 years ago, Shakyamuni Buddha attained enlightenment under the bodhi tree and began teaching the sutra and tantric paths to liberation and full enlightenment. By the 3rd Century B.C., Mongolia had adopted these precious teachings.

Khamba Lama Choijamts

Mongolian states of Khunuu and Neron had Buddhism as their state religions. Several ancient Mongolian states had Buddhism as their state religions. That was the first stage of Buddhism up until Chinggis Khan.

Пүрэвбат

Залуу үе маань өөрсдийнхөө мөн чанар, соёлоо мэдэхгүй байна. Монголыг харийн соёлын түрэмгийллээс хамгаалан, залуу үеийг зөв залж, чиглүүлэх юмсан гэж боддог. Түүнчлэн бидний үеийнхэн хуучин, шинэ үеийнхэний хооронд магадгүй гүүр нь болж өгөх хэрэгтэй байгаа юм.

Баруунд түргэн далайцтай дэлгэрч байгаа Бурханы шашин нь Энэтхэг орноос гаралтай. 2500 жилийн тэртээ бурхан Шагжмуни Бодь модны дор гэгээрлийг олсон агаад нирваан хийгээд гэгээрэлд хүрэх судар, тарнийн ариун сургаалиа айлдсан билээ. Тэгвэл энэхүү эрдэнэт сургаалийг нь монголчууд тэртээ МЭӨ III дугаар зуунд анхлан хүртсэн түүхтэй.

Чойжамц Хамба

Бурханы шашин Монголд 2000 гаруй жилийн тэртээ анх дэлгэрсэн юм. Манай эриний өмнө оршин байсан монгол угсааны Хүннү болон Нирун зэрэг улс нь Бурханы шашныг төрийн шашнаа болгосон байдаг. Энэ мэтчилэнгээр Чингис хааныг хүртэл нөлөө бүхий шашин хэвээр уламжлагдсаар иржээ. Энэ үеийг **«Монголын Бурханы шашны эхэн үе»** гэж нэрлэдэг.

Early Mongolian Buddhism

The Great Khan's armies conquered all of Asia except Tibet. Tibetans first maintained their independence by paying tax. When Chinggis Khan died, Prince Godon requested Sakyapandita to come to Mongolia to teach Buddhism to the Mongolian people.

Sakyapandita traveled with his nephews as hostages to Mongolia in order to avoid bloodshed and mass destruction. They soon succeeded in converting the Godon Khan to Buddhism. The Sakyapandita was the supreme ornament of the Kublai Khan's kingdom after his arrival. The purity of his attainments and his teachings created great faith in the Buddhist path among the Kublai Khan and his court.

After the death of Sakyapandita, his nephew, Pandhma Lama, took his place, becoming the Kublai Khan's spiritual advisor and teacher.

Buddhism was the most popular religion in court circles but did not blossom in the general population until Altan Khan invited the Tibetan Iama, Sonam Gyatso, to Mongolia in 1578. Чингис хааны цэргүүд Төвдөөс бусад Азийн бүх улс орнуудыг аль хэдийн эзэлсэн байлаа. Төвдүүд эхлээд бэлэг сэлт, татвар ногдол төдийхнөөр тусгаар тогтнолоо арайхийн торгоож байв. Харин Чингис хааныг насан эцэслэсний дараа хан хүү Годан, Саж бандидийг залж, Монголын ард түмэнд Бурханы шашныг дэлгэрүүлж өгөхийг хүсчээ.

Харин Саж бандид, монголчуудын түвдүүдэд учруулж болзошгүй цус урсалт хийгээд эвдрэл сүйрлээс урьдчилан сэргийлж, ач хүүгийн хамт Монголыг яаралтай зорьжээ. Саж бандидийн сургааль, номлолыг сонссон Годан хаан удалгүй Бурханы шашинд орсон юм. Саж бандид Монгол гүрэнд ирсэн даруй Хубилай хааны номын багш буюу «Гүрнийн дээдийн чимэг-Улсын багш» болжээ. Түүний ариун сургааль, шид хүч нь Хубилай хаан болон түүний ордныхоныг Бурханы шашинд гүн их сүсэглэхэд нөлөөлөв.

Саж бандид таалал болсны дараа түүний ач Пагва Лам Хубилай хааны шашны зөвлөгч, багш нь болсон юм.

Бурханы шашин зөвхөн дээдсийн хүрээнд л тархсан бөгөөд харин өргөн олонд төдийлөн дэлгэрээгүй байсаар 1578 онд Төвдийн лам Сонамжамцийг Алтан хаан Монголд урьснаас хойш л ард түмний дунд өргөн дэлгэр түгжээ.

Khamba Lama Choijamts

From the Kublai Khan to the Togon Timo Khan, there were 16 kings in the Mongolian-Yuan Dynasty Empire. At that time, everybody regarded Buddhism as the state religion for two to three hundred years. Buddhism was the most important religion in Mongolia. That was the middle stage of Buddhism. Then the 3rd Dalai Lama came to Mongolia.

The Dalai Lama

Altan Khan conferred on him the title of Dalai Lama or, Ocean of Wisdom. Sonam Gyatso, His Holiness the 3rd Dalai Lama, was considered the emanation of Chenrezig, the Buddha of Compassion. He dedicated his life to teaching the dharma to the people of Mongolia and Buddhism began to flourish in popular culture.

The Mongols based their Buddhist doctrine, practice and communal organization on Tibetan models. But they developed and adapted them in a distinctive way. Examples can be seen in the extraordinary art and architecture used in the building of the first Buddhist monastery in Mongolia.

Чойжамц Хамба

Хубилай хаанаас Тогоонтөмөр хаан хүртэл 16 хаад Монголын төрийг барьсан түүхтэй. Үүнтэй хамт Бурханы шашин 300 жилийн турш төрийн шашин хэвээр байлаа. Энэ үеийг «Монголын Бурханы шашны түүхийн дунд үе» гэж үздэг. Дараа нь Гуравдугаар Далай Лам Монголд морилсон юм.

Монголын Алтан хаан түүнд анхлан "Далай Лам" буюу "Билгүүн ухааны далай" гэсэн цол олгожээ. Дээрхийн Гэгээнтэн гуравдугаар Далай Лам Сономжамцийг Энэрэхүйн Нинж сэтгэлийн бурхан-Жанрайсэгийн хувилгаан гэдэг. Тэрээр өөрийн бүхий л амьдралаа Монголын ард түмэнд ном айлдахад зориулсан бөгөөд Бурханы шашин ч Монголд нэн хүчтэй дэлгэрч эхлэв.

Монголчууд Бурханы шашны сургааль төдийгүй нийгмийн бүтцээ Түвдийн загвараар зохион байгуулсан хэдий ч үндэсний хэв шинжээрээ хүчтэй баяжуулж чаджээ.

2. Highlights & Heroes of Mongolian Buddhism

Erdene Zuu, built in 1586 by Abdon Khan, near the old capital of Karakorum. Erdene Zuu was said to have had 10,000 monks, 108 Som dancers and 30 temples. It was surrounded by 108 stupas.

The extraordinary artist and sculptor, Zanabazar, born in 1635, became the first Khalkha Jebtsumdampa, or Bogd Khan. During his reign, as head of state, Zanabazar brought a new way to Mongolian education, culture, society, and political life. His disciples established the capital of Mongolia in Ulaanbaatar. The symbol that he created became the Mongolian State Coat of Arms emblem.

Buddhism continued to grow in popularity and influence in Mongolian society. Within a few decades, Mongolian culture had transformed to include over 700 monasteries and one-third of the male population were ordained monks.

Mongolian monks and scholars excelled in the study of philosophy. So much so, that when the 13th Dalai Lama came to visit in 1904, Mongolian monks defeated him in the art of debating Buddhist philosophy. Үүний тод нэгэн жишээ бол, 1586 онд Хар-Хорум хотын ойролцоох Автай хааны бариулсан Монголын эртний сүмүүдийн нэг болох гайхмаар ур хийц, уран барилгын шийдэл бүхий «Эрдэнэ-зуу» хийд юм. Эрдэнэ зууд 10000 хуварга шавилан суудаг, 108 цам гардаг, түүнийг тойрсон 108 суваргатай, 30 сүм бүхий томоохон цогцолбор байжээ.

Монголын Анхдугаар Богд Жавзандамба, төгс урлаач, барималч Занабазар бээр 1635 онд мэндэлжээ. Халх монголын хаан-Богд Занабазар тухайн үедээ монголын боловсролын тогтолцоо, улс төр, соёлыг бүхэлд нь шинэ замд хөтлөн оруулж, Монголын нийслэлийг үндэслэв. Өдгөө ч хэрэглэгдсээр буй Монгол улсын сүлд төрийн тэмдэг "Соёмбыг" Өндөр гэгээн Занабазар бүтээжээ.

Ийнхүү Бурханы шашин Монголын нийгэмд улам бүр хүрээгээ тэлж, нөлөө нь ихсэв. Энэ цаг үеэс хойш тун удалгүй Монгол улсад 700 гаруй сүм хийд босч, нийт эрчүүдийнх нь гурваны нэг нь хуварга болов.

Бурханы шашны арван ухаанд төгс мэргэжсэн Монголын мэргэд, хуваргууд олноор төрөн гарав. Үүний нэг жишээ нь, Монголын эрдэмт мэргэд 1904 онд 13 дугаар Далай Ламыг Монголд ирэхэд нь гүн ухааны ном хаялцан ялж байсан баримт байдаг.

2. Highlights & Heroes of Mongolian Buddhism

The Eighth Jetsumdampa was the secular and spiritual leader of Mongolia until his death in 1924. The period of Soviet domination began and the threat to the survival of Mongolian Buddhism became extreme.

Dark Days

Lovon Lama

In 1937, during the political repression, I was 24 or 25 years old. At that time in Mongolia, there were 700 monasteries and temples. But, between 1937 and 1938, in only 2 years, all the temples and monasteries were destroyed. There were 100,000 monks and students at 700 monasteries and temples and they were all executed.

This is a picture of my guru-teacher, Tara-teacher, the one that was 58 years old. And this picture was shot just before his execution. He was executed on October 25th, 1937.

Монголын төр шашныг хослон барьсан Наймдугаар Богд хаан 1924 онд тэнгэрт хальснаас хойш Монголд Оросын нөлөө илтэд давамгайлж, Монголын Бурханы шашны цаашдын ирээдүйд ноцтой аюул учирч эхэлсэн юм.

ГОМБО лам

1937 оны улс төрийн хэлмэгдүүлэлтийн үед би 24 настай байлаа. Монголд байсан 700 гаруй сүм хийд ердөө л хоёрхон жилийн дотор үгүй болсон. Хамгийн харамсалтай нь, тэнд шавилан сууж байсан 100 000 гаруй лам хуврагуудыг ч бас хамтад нь устгачихсан юм шүү дээ.

(Өвгөн лам зураг үзүүлнэ) Энэ бол миний багш, «Дарь эхийн хувилгаан», 58 настай лам хүн. Түүнийг буудан алахынх нь өмнө авсан зураг. Багш маань 1937 оны 10 сарын 25-нд буудуулсан даа.

Khamba Lama Choijamts

They were very black days in Mongolian history because these statues and tangkas were collected from centuries ago and they were the zenith of Mongolian art. They showed the Mongolian peoples development and their way of relating to spiritual things. This flourishing of art and of Mongolian culture was destroyed completely.

The Statue of Chenrezig

In 1911, a vast statue of Chenrezig, the Buddha of Compassion, was built at Gandan Monastery. During the 1930s, it was destroyed and the bronze statue was melted down. The metal was used to make bullets.

Today, the statue has been reconstructed and brings a message of compassion and loving kindness to all who view it.

Чойжамц Хамба

Энэ бол Монголын түүхийн «гамшигт хар өдрүүд» байсан юм. Яагаад гэвэл, Монголын ард түмний хэдэн зуун жилийн нөр хөдөлмөр, ур хийц, хосгүй төгөлдөр урлагийн бүтээл болсон бурхан шүтээний давтагдашгүй урлагийг нь бүрмөсөн үгүй хийчихсэн юм. «Бурхан шүтээн» нь Монголын ард түмний оюун санааны ухаарал хийгээд нарийн торгон мэдрэмжийг тодорхой гаргасан урлагийн төдийгүй сэтгэлгээний үнэт бүтээлүүд байсан юм.

1911 онд Энэрэн Нигүүлэхүйн их Бурхан-Жанрайсэгийг Гандан хийдэд бүтээжээ. Харин 1930-аад оны үөд Оросууд тэр сайхан шүтээнийг бүрмөсөн буулгаж аваад явсан байна. Авч явсан шүтээнээ хайлуулан сум хийсэн тухай баримт байдаг.

Тэгвэл өнөөдөр энэ авралт бурханыг дахин бүтээсэн бөгөөд «энэрэн нигүүлсэхүйн ариун билэгдэл» болон сүндэрлэжээ.

Practiced in Secret

The Arkhangai Monastery, once a thriving community of monks, was one of hundreds of monasteries destroyed. The survivors of this lineage continue to practice in a ger near the site.

For 70 years, Buddhism was practiced in secret. The flame of faith kept alive through the quiet devotion of many Mongolian people. Much of the art and literature of Mongolia's precious history was buried or hidden to save them from destruction. These relics were found in the backyard of the prominent Buddhist nunnery, Dara Ekh.

In 1938, the curator of the Rabjaa Museum hid the entire collection of relics belonging to the famous Kharmapa Lama, Dandan Rabjaa, in a series of seventeen caves. He told no one of the location until 1965, when he passed the curatorship to his grandson, only 5 years old at the time. Here (photo), Altangerel holds the snuff bottle given to him by his grandfather as a symbol of the position of curator of the Rabjaa Museum. Altangerel restored the treasures to the museum in 1991.

Архангай аймагт орших энэхүү сүм бол аймшигт хэлмэгдлийн үед устгалд өртөж, сүйрсэн тэрхүү зуу зуун сүмийн зөвхөн нэг нь. Амьд үлдсэн цөөн хэдэн лам нар нь одоо, хуучин сүм байсан газраасаа холгүйхэн гэр хийдэд шавилан ном хурж байна.

Аймшигт далаад жилийн турш Монголчууд бурханы шашнаа далд, нууцаар, шүтэж байв. Хэдийгээр нууцгайхан байвч итгэл бишрэлийн гал Монголын сүсэгтэн олны зүрхэнд чимээгүй ассаар байсан юм. Монголын түүх, соёл, шашин, урлаг, уран зохиолын үнэт өв, эд өлгийн ихэнхи нь эсвэл шатаагдсан, эсвэл сайн санаатан сүйрэлээс далдлан нуусанаас л аврагдан үлдсэн байлаа. Таны харж буй эдгээр шашны эд зүйлсийг эмэгтэйчүүдийн «Дарь Эхийн сүм»-ийн ард далдлан хадгалсан байжээ.

Өдгөө «Данзанравжаагийн гэр мүзей»-н эрхлэгчийн өвөг эцэг, ач буянтай тэр буурал 1938 онд, Монголын их лам, Говийн догшин ноён хутагт Данзанравжаагийн хэрэглэж явсан эд зүйлсийг 17 агуйд нууцлан хадгалж авч үлдэж чадсан байна. Тэрээр 1965 онд таалал төгсөхийнхөө өмнөхөн хүнд хэлэлгүй чандлан нууцалж, 5 настай ач хүүдээ энэ тухай хэлж өвлүүлжээ. Одоо ач хүү Алтангэрэл нь Данзанравжаагийн гэр музейн эрхлэгчийн «бэлэг тэмдэг» болсон, өвөөгийнхөө гэрээслэж үлдээсэн хөөргийг барьж

At the end of the 19th century, a prophecy was written about the future of Buddhism in Mongolia.

Bakula Rinpoche

Sonam Wangchuk

The prophecy says there will be destruction of Buddhism in Mongolia and that following all this, the Bakula will come and help restore Mongolian Buddhism. And this prophecy was done over a hundred years ago.

Bakula Rinpoche was appointed Ambassador to Mongolia by the Indian government in 1989. He is the reincarnation of Bakula Arhat, one of the 16 enlightened disciples of Shakyamuni Buddha. сууна. Алтангэрэл эдгээр эд зүйлсийг 1991 онд эмхлэн музей болгосон аж.

Монголын Бурханы шашны ирээдүйг урдаас зөгнөн үзүүлсэн нэгэн бичиг 19 дүгээр зууны сүүлчээр үйлдэгджээ.

Соном Ваанчиг

Энэхүү бичигт, Монголд Бурханы шашин хэзээ, хэрхэн доройтохыг урьдчилан алдаагүй хэлсэн байдгийн дээр «Бурханы шавь» 16 архадын нэг болох Бакула Ринпочэ Монголд ирж, шашныг нь сэргээх талаар ч бас тэнд өгүүлсэн байдаг. Энэ бивангарьд бичгийг 100 илүү жилийн тэртээ Монголын их зөнч лам нар айлджээ.

Энэхүү бивангарьд үзүүлсэн бичгийн дагуу зуун жилийн дараа буюу 1989 онд Бакула Рэнпочег Энэтхэг улсаас Монголд суух Элчин сайдаар томиложээ. Тэрбээр «Бурханы шавь», гэгээрсэн 16 архадын нэг болох «Бакула архад» билээ.

Bakula Rinpoche

In 1970, I had these monks, the Boiyats and the Mongolians and monks from different countries. We were together. It was the first time ever that we were able to bring His Holiness the Dalai Lama to Mongolia and that is a process that helped in a way to rekindle Buddhism in Mongolia.

In 1989, His Holiness the 14th Dalai Lama, returned to Mongolia. He gave the auspicious Kalachakra initiation and instructed Mongolian monks how to build Kalachakra sand mandala. These monks were the first trained in this precious representation since communism.

Batbold Baast

Communist ideology was such a strong one. And in my childhood, we used to even have a kind of game, that "You a lama!" or "You're a monk!" from like this old age. It was that kind of relationship. And in the movies, in the books, about the past, about the monks was such a low esteemed one. But I mean they were shown as like enemies of the people because they poisoned and exploited the Mongolian people. And also they were lying and that they didn't have anything. Everything was like anti-Buddhism.

Бакула Ринпоче

Анх 1970-аад онд монгол, буриад хийгээд өөр орны бидний хэсэг хуваргууд 14-р Далай Ламыг Монголд анх авчирах аргыг сэдэж үйлдсэн билээ. Энэ нь Монголын Бурханы шашин дахин сэргэхэд нааштай үйл явдал болсон гэж би боддог юм.

1989 онд 14 дүгээр Далай Лам Монголд дахин заларч, «Дүйнхорын ван» тавьсан нь тун чиг билэг дэмбэрэлтэй үйл явдал болсон юм. Тэрбээр, «Дүйнхорын мандал», «жинхорыг» хэрхэн бүтээдгийг айлдсан билээ. Эдгээр лам хуврагууд нь энэхүү чухал номд суралцсан, коммунизмын дараах анхны хуврагууд болцгоожээ.

Батболд

Намайг багад, Коммунист үзэл суртал маш хүчтэй байлаа. Тэр бүү ч хэл хүүхдүүд хүртэл хоорондоо нэгнээ «чи лам», «тэр лам» гэж хочилдог байсан нь «лам хуврага» байх гэдэг сайн юм биш гэсэн ойлголт авснаас болсон хэрэг байв. Кино, ном зохиолуудад лам хүнийг хамгийн муугаар үзүүлж, харуулдаг байлаа. Тэднийг «ардын дайсан» гэж нэрлэдэг, яагаад гэвэл тэд Монголын ард түмнийг хордуулж, мөлждөг байсан, эсвэл худал хэлж мунхруулдаг гэх мэтээр ямар ч зай завсаргүй муулдаг, ерөнхийдөө Бурханы шашны эсрэг харгис үзэл суртал ноёрхож байсан гэхэд болно.

Sonam Wangchuk

I mean you couldn't imagine, that ten years ago this country was something like, the situation at that time was terrible. I remember, people coming to (Bakula) Rinpoche. They were so fearful, you know. Everybody is being watched and listed, but then, still people would come. But when freedom was kind of restored by, the political freedom that was announced, then you should have seen the floods of people coming to the (Indian) Embassy.

Bakula Rinpoche

So, I feel that it is time for us to return, to pay back in a way, to Mongolia, for what Mongolians have done in the past. In order to contribute to the flourishing of Buddhism today.

Соном Ваанчиг

10 жилийн өмнөх Монгол орон дүрслэгдэхийн аргагүй бэрх, өөрөөр хэлбэл, байдал маш хүнд байв. Зарим хүмүүс, Ринбучи лам дээр ирэхдээ ихэд айж эмээсэн байдалтай байдаг байсныг би тов тодорхой санаж байна. Лам дээр ирсэн хүн болгоныг харж, тусгай нэрийн жагсаалтанд оруулдаг байсан хэдий ч хүмүүс адис авахаар цувсаар байдаг байлаа. Харин шашин шүтэх эрхийг нь өгснөөс хойш хүмүүс үерийн ус шиг Энэтхэгийн элчин сайдын яам руу урсч байлаа.

Бакула Ринпоче

Бурханы шашныг мандуулан дэлгэрүүлж, хүн төрөлхтний оюуны сан хөмрөгт монголчуудын оруулсан үнэтэй хувь нэмэр, эртний түүхэн гавъяаг нь эргэн санах хэрэгтэй. Өдгөө шашин нь доройтсон энэ хүнд хэцүү үед нь дэлхий нийт монгол зонд хариу туслах цаг нь иржээ гэж би бодож байна.

The Future

Lama Zopa Rinpoche

Generally, without understanding Buddhism, you cannot have wisdom, to really be able to discriminate what's the right path, what's the right religion, what's the wrong religion. You cannot. Without learning Buddhism, you cannot, you don't have the eye to see what is the right religion and the wrong religion, what is the right path or wrong path. You cannot. You don't have the wisdom to discriminate.

Ven. Purevbat

Not only do I want to restore the dying tradition of Mongolian culture and art, but I want to develop it better than before.

Gunjiimaa

I pray that all people, in Mongolia as well as around the world, become Buddhist. Because it will make them happy. and it will make more peace.

Лама Зопа

Бурханы шашныг судлахгүйгээр та аль нь зөв зам болох, аль нь зөв шашин болохыг үнэхээр ялган салгаж чадахгүй. Энэ бол зүгээр л боломжгүй юм аа. Бурханы шашныг судлалгүйгээр та зөв, бурууг ялган үзэх билгийн мэлмийг олохгүй. Бурханы шашныг судлахгүйгээр аль нь зөв шашин, аль нь буруу шашин гэдгийг ухаарах билгүүн ухааныг нээхгүй юм.

Пүрэвбат

Монголынхаа соёл урлагийг зөвхөн сэргээн хөгжүүлээд зогсохгүй улам баяжуулан дэлгэрүүлэхийг би хүсч байна.

Гүнжиймаа

Монголчууд төдийгүй дэлхийн олон ард түмнүүд Буддын шашинтай болоосой гэж би мөрөөддөг, яагаад гэвэл, ингэснээрээ улам их аз жаргалан болон улам их амар амгаланг мэдрэх болно.

His Holiness the Dalai Lama

Many people throughout the world, Buddhists and non-Buddhists alike, when they think of the Buddha, Buddhist tradition as a whole, what comes to mind are such qualities as compassion, serenity, and equanimity. So this is what Buddhism has become widely known for. This being the case, especially for those of us being raised in the Buddhist tradition, whose parents are Buddhists, it is especially our responsibility to study Buddhism, to practice it, to be our best of service to the whole world, to be of whatever benefit we can.

Richard Gere

To succeed, we need to make this practice our own. So it is vitally important to draw from our own cultures to establish a foundation for the development of these practices. We'll find the heart of our practice in the strengths of our heritage.

Dedication

Please dedicate the merit you accumulated by reading this chapter so that you and all beings may be free of suffering and quickly attain the state of full enlightenment.

Дээрхийн Гэгээнтэн Далай лам

Дэлхийн хаа ч бай, ямар ч шашинтай, тэр ч бүү хэл шашинд огт итгэдэггүй хүн хүртэл Бурхан Буддагийн тухай, Бурханы шашны тухай бодох төдийд л тэдэнд «энэрэн нигүүлсэх», «намуун тогтуун», «амгалан чанар» л хамгийн түрүүн санаанд нь буудаг. Энэ хосгүй чанараараа л Бурханы шашин илүү их алдаршсан юм. Нэгэнт учир иймээс, ялангуяа Буддын шашны өв уламжлалаар өсч өндийсөн бид бүхэн л энэхүү шашнаа үнэнээр нь сурч мэдээд зогсохгүй түүгээр замнан амьдарч, дэлхий ертөнцөд өөрсдийн чадлын хирээр илүү их ач тус хүргэх нь туйлаас чухал байна.

Ричард Гир

Амжилтанд хүрэхийн тулд бид өөрсдөө л хичээх хэрэгтэй. Та нэгэнт Бурханы сургааль увидасаар амьдралаа тэтгэхээр шийдсэн бол, түүний үндэс суурийг нь өөрсдийнхөө, өөрөөр хэлбэл, монголынхоо соёлоос эрж олох нь амин чухал юм. Номын сургаалийн охь шимийг та гагцхүү өөрийнхөө, таны мах цусанд шингэсэн тэрхүү уламжлалт шашныхаа хүчээр л олно.